

**Хүүхдийн хамтын асрамж: Олон улсын туршлага ба
МОНГОЛ УЛС ДАХЬ ТУЛГАМДСАН АСУУДАЛ**

**Joint Child Custody: International Practices
and Challenges in Mongolia**

Мөнхтөрийн Балжинсүрэн

Хууль зүйн ухааны бакалавр (LL.B.).

Улаанбаатар хот, Монгол Улс

baljka18@gmail.com



[Товч утга]

Энэхүү өгүүлэл нь гэрлэлт цуцлагдсаны дараах хүүхдийн асрамжийн эрх зүйн зохицуулалтыг олон улсын туршлага болон Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд харьцуулан шинжилсэн болно. Өгүүлэлд ганцаарчилсан болон хамтын асрамжийн хэлбэрүүд, хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах зарчим, олон улсын чиг хандлагыг авч үзэв. Монгол Улсад хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид, ялангуяа эхийн асрамжид үлдээх шүүхийн шийдвэр зонхилж байгаа нь эцэг, эхийн эрх, үүргийн тэнцвэрт байдал болон хүүхдийн эцэг, эхтэйгээ харилцах эрхийг хязгаарлах эрсдэлтэйг судалгааны үр дүн харуулж байна. Олон улсын туршлагаас харахад хамтын асрамжийг хүлээн зөвшөөрснөөр хүүхдийн эрхийг илүү үр дүнтэй хамгаалах боломжтой бөгөөд Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатайг дүгнэсэн. Улмаар Монгол Улсад хамтын асрамжийн зохицуулалтыг нэвтрүүлэх боломжийн талаар санал, зөвлөмж гаргав.

[Түлхүүр үг]

Хүүхдийн асрамж, ганцаарчилсан асрамж, хамтын асрамж, гэр бүлийн эрх зүй, хүүхдийн дээд ашиг сонирхол, эцэг, эхийн эрх, үүргээ хамтран хэрэгжүүлэх.

I. Оршил

Гэрлэлт цуцлагдсан тохиолдолд эхнэр, нөхрийн харилцаа дуусгавар болдог боловч эцэг, эх байх харилцаа хэвээр үлддэг. Иймээс хамтын амьдралаа дуусгавар болгосон эцэг, эхийн хувьд хүүхдээ хэрхэн асран хамгаалах, эцэг, эхийн эрх, үүргээ ямар хэлбэрээр хэрэгжүүлэх нь эрх зүйн болон нийгмийн чухал асуудал юм.

Олон улсад хүүхдийн асрамжийг ганцаарчилсан асрамж (sole custody) болон хамтын асрамж (joint custody) гэсэн үндсэн хэлбэрүүдээр зохицуулж байна. Сүүлийн хэдэн арван жилд олон улс орон хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хамтын асрамжийн зохицуулалтыг гэр бүлийн хууль тогтоомждоо нэвтрүүлэх хандлага нэмэгдэж байна.

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хүрээнд гэрлэлт цуцлагдсан тохиолдолд хүүхдийг ихэвчлэн эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх байдлаар шийдвэрлэдэг. Шүүхийн практик болон статистик мэдээллээс харахад хүүхдийг эхийн асрамжид үлдээх хандлага зонхилж байгаа нь ажиглагдаж байна. Ийнхүү хүүхдийн асрамжийг ганцаарчилсан хэлбэрээр шийдвэрлэх нь хүүхдийн эцэг, эхтэйгээ харилцах эрх, эцэг, эхийн эрх, үүргийн тэнцвэрт байдал, хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах асуудалд тодорхой хүндрэл үүсгэж болзошгүй юм.

Иймд энэхүү өгүүллийн зорилго нь хүүхдийн хамтын асрамжийн ойлголт, онолын үндэс болон олон улсын нийтлэг чиг хандлагыг судалж, Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан шинжлэхэд оршино. Мөн хамтын асрамжийн давуу болон сул талын талаар хийгдсэн судалгаануудыг тоймлон шинжилж, Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох боломжийн талаар санал, зөвлөмж дэвшүүлэхийг зорив.

II. Хүүхдийн асрамж ба түүний хэлбэрүүд

Гэрлэлтээ цуцлуулах эсхүл салах гэх мэтээр нэгэнт хамт амьдрахаа больсон хүмүүсийн хувьд эцэг, эх байх эрх, үүргээ хэрхэн хэрэгжүүлэх, биелүүлэх нь шийдвэрлэх чухал асуудлуудын нэг юм.¹ Иймд энэ асуудлыг талууд тохиролцон шийдвэрлэнэ, тохиролцоо байхгүй бол хөндлөнгийн этгээд шийдвэрлэж өгч байна. Энэхүү хөндлөнгийн этгээд нь гэрлэлт цуцлалтын хэргийг шийдэж бүй этгээд болох шүүх юм. Зарим улсад (Жишээ нь: АНУ, Өмнөд

¹ Government of Canada, Department of Justice, Section 3: Parenting after Separation— Focusing on Your Children - Making Plans: A Guide to Parenting Arrangements after Separation or Divorce. <https://www.justice.gc.ca/eng/fl-df/parent/mp-fdp/p4.html> (last accessed: 2026.03.13)

Солонгос) шүүх энэ асуудлыг шийдвэрлэхдээ мөн хөндлөнгийн этгээд буюу сэтгэл зүйч, нийгмийн ажилтан зэрэг мэргэжилтнүүдийн дүгнэлт, зөвлөмжийг харгалзан үздэг. Товчхондоо гэрлэлт цуцлах эсхүл хамтран амьдарч байсан хосууд салах тохиолдолд хүүхэд эцэг, эхийнхээ хэнтэй нь цаашид амьдрах, хүүхдээ асран хамгаалах, өсгөн хүмүүжүүлэхтэй холбоотой (сургууль, эрүүл мэнд, шашин шүтлэг гэх мэт) шийдвэрүүдийг хэн гаргах вэ гэдгийг шүүхээс тодорхойлохыг “хүүхдийн асрамж” тогтоох гэж ойлгож болно.

Харин хүүхдийн асрамжийн хууль зүйн үр дагаврыг дараах байдлаар тодорхойлсон байна:²

1. Оршин суух газраа сонгох эрхийг хэрэгжүүлэх;
2. Хүүхэд эд хөрөнгө өмчлөх эрхээ хэрэгжүүлэх;
3. Хүүхдийн бусдад учруулсан хохирлыг арилгах;
4. Хүүхдийн боловсрол, эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх эрх;
5. Хүүхэдтэй уулзах эрх.

Олон улсад хүүхдийн асрамжийг ерөнхийд нь ганцаарчилсан ба хамтын, хууль зүйн ба биеэр асрамжлах гэж ангилж байна. Хүүхдийн ганцаарчилсан асрамжийн хувьд хүүхдийг асрамжлах үүргийг гэрлэлт цуцлалтын дараа эцэг, эхийн хэн нэг нь дангаар хүлээх асрамжийн хэлбэр юм.³ Энэ нь одоо Монгол Улсад хэрэгжиж байгаа хэлбэр бөгөөд шүүх гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлийг шийдвэрлэх хүрээнд хүүхдийн асрамжийн асуудлыг мөн шийдвэрлэхдээ хүүхдийг эцэг, эхийн хэн нэгийнх нь асрамжид үлдээж, харин асрамжийн үүрэг хүлээгээгүй эцэг, эхийн хэн нэгнээс хүүхдийн тэтгэлэг гаргуулахаар нийтлэг байдлаар шийдвэрлэж байна. Өөрөөр хэлбэл хүүхдийг асрамжлах үүргийг гэрлэлт цуцлалтын дараа эцэг, эхийн хэн нэг нь дангаар хүлээх нь ганцаарчилсан асрамжийн хэлбэр юм.

Хүүхдийн хамтын асрамж буюу эцэг, эх байх үүргээ хамтран хэрэгжүүлэх гэдэг нь хүүхдийн эцэг, эх хамтын амьдралаа дуусгавар болгосны дараа эцэг, эх хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, тэжээн тэтгэх үүргийг хамтран хүлээхийг ойлгоно. Үүн дотор Joint legal custody буюу хамтын хууль зүйн асрамж гэдэг нь эцэг, эх нь хүүхдийнхээ хувьд чухал ач холбогдол бүхий буюу хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, шашин шүтлэг, халамж, хамгаалалттай холбоотой томоохон, санхүүгийн

² Жигжидийн Лхагвасүрэн, “Монгол Улс дахь хүүхдийн асрамжийн эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал”, *Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр бүл*” олон улсын эрдэм шинжилгээний хурал (I хэсэг) (2025.06.25), Улаанбаатар хот, Монгол улс, <https://legaldata.mn/news/444>

³ Justia, Joint vs. Sole Custody, <https://www.justia.com/family/child-custody-and-support/child-custody/joint-vs-sole-custody/> (last accessed: 2026.03.13)

ач холбогдол бүхий шийдвэр гаргахад оролцох, хамтран шийдвэр гаргахтай холбоотой эцэг, эхийн эрх, үүргийг тодорхойлдог.⁴ Joint physical custody буюу биеэр хамтран асрамжлах гэдэг нь эцэг, эх байх үүрэг, хариуцлага болон амьдрах орон байр, бусад ахуйн асуудлуудыг хамтран хариуцах тухай юм.⁵

Гэхдээ хүүхдийн хамтын асрамж нь яг ийм байх ёстой гэж нарийн зааж хуульчлах нь бараг боломжгүй. Учир нь эцэг, эх хоорондын харилцаа, амьдралын нөхцөл байдал, хүүхэд эцэг, эхтэйгээ харилцах харилцаа гэх мэт харгалзаж үзэх олон хүчин зүйлс байх бөгөөд хүүхэд болон тухайн гэр бүлд тохирсон, хүүхдийн ашиг сонирхлыг харгалзаж үзсэн шийдвэр, шийдлийг тухай бүрд нь тодорхойлох нь зүйтэй байна.

Мөн олон улсад эцэг, эх хүүхдээ хамтран асрамжлахтай холбоотой co-parenting гэсэн ойлголт байгаа бөгөөд joint custody нь илүү хууль зүйн агуулгатай бол co-parenting гэдэг нь эцэг, эх нь хамт амьдрахаа больсны дараа хүүхдийн эцэг, эхийн хувьд хүлээх үүргээ хэрхэн хамтран хэрэгжүүлж байгааг илэрхийлэх агуулгатай. Тухайлбал хамтын амьдралаа дуусгавар болгосон эцэг, эхчүүдийг хүүхдээ хамтран асрамжилж буй хэв маягаас нь хамаарч сайн найзууд, нөхөрсөг хамтрагчид, параллель эцэг, эх, ууртай хамтрагчид, ширүүн дайсагнагчид, сарнисан хос гэсэн нийтлэг 6 ангилалд ангилж болохоор байна гэж үзсэн судалгаа байна.⁶

Co-parenting-н харилцааг ямар байхыг тодорхойлоход хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих шаардлагатай бөгөөд өөрөөр хэлбэл гэрлэлт цуцлалтын дараах эцэг, эх хоорондын харилцааны гол цөм нь хүүхэд тул хүүхдийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих нь зүйтэй. Иймд Co-parenting харилцаа ямар байх нь олон хүчин зүйлээс шалтгаална. Жишээ нь, хүүхдийн эцэг, эх хоорондоо нүүр тулж ярилцах боломжтой эсэх, тэдгээрийн хоорондын харилцаа, гэр бүлийн хүчирхийлэл гэрлэлт цуцлалтад нөлөөлсөн эсэх, хүүхдийн хүсэл зориг ямар байх вэ, хүүхдийн нас, эцэг, эхийн ажил, санхүүгийн чадамж, эцэг, эх хүүхэдтэйгээ цаг хугацааг үр дүнтэй өнгөрөөж, харилцаж чаддаг эсэх гэх мэт.

III. Олон улсын эрх зүйн зарчим ба хүүхдийн дээд ашиг

⁴ Ibid.

⁵ Pruett MK, Hoganbruen K., “Joint Custody and Shared Parenting. Research and interventions.”, *Child Adolesc Psychiatr Clin N Am* (April 1998). 274.

⁶ Amato, Paul R., Jennifer B. Kane, and Spencer James, “Reconsidering the ‘Good Divorce.’”, *Family Relations* 60, no. 5 (2011): 511–524. <https://doi.org/10.1111/j.1741-3729.2011.00666.x>. (last accessed: 2026.03.13)

сонирхол

Олон улсын хэмжээнд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүний эрхийн түгээмэлт тунхаглал болон Хүүхдийн эрхийн тухай конвенц нь хүүхдийн эрхийн талаар баримтлах үндсэн суурь баримт бичгүүд юм. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 25 дугаар зүйлийн 1 ба 2 дахь хэсэгт гэр бүл, түүний гишүүдийн амьжаргаа, нийгмийн хамгаалал, хүүхдийн эрх тэгш байдлын талаар суурь зарчмуудын асуудлуудыг тодорхойлж өгсөн.⁷

Монгол Улс Хүүхдийн эрхийн тухай конвенцод 1990 онд нэгдэж орсон бөгөөд тус конвенц нь дараах тулгуур 4 зарчимд үндэслэдэг:

- Хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх
- Хүүхдийн дээд ашиг сонирхол
- Хүүхдийн эсэн мэнд амьдрах ба хөгжих эрх
- Хүүхдийн үзэл бодолд хүндэтгэлтэй хандах

Тус конвенцийн 3 дугаар зүйлд хүүхдийн талаар шийдвэр гаргахдаа төрийн байгууллага, шүүх юуны өмнө хүүхдийн ашиг сонирхлыг харгалзан үзэхийг заасан. Мөн Конвенцийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт хүүхдийн хүмүүжил болон хөгжилд эцэг, эх тэгш бөгөөд гол хариуцлага хүлээх бөгөөд эцэг, эх нь ийнхүү үүрэг, хариуцлага хүлээхдээ хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах нь гол баримтлах зарчим нь гэжээ. Иймд Конвенцийн дагуу хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд баримтлах үндсэн зарчим нь “хүүхдийн дээд ашиг сонирхол” (the best interests of the child) юм. Хүүхдийн асрамжтай холбоотой бусад улсуудын туршлагыг судлахад ч мөн шүүх хүүхдийн асрамжийг шийдвэрлэхдээ, эцэг, эх хүүхдийн асрамжийн асуудлаар тохиролцоо хийхдээ баримтлах гол зарчим “хүүхдийн дээд ашиг сонирхол”-г нэн тэргүүнд тавих байна.

IV. Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын хууль тогтоомжид хүүхдийн эрх, ашиг сонирхлыг төр хамгаалах үндсэн зарчмыг тогтоосон байдаг. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хууль⁸ болон Гэр бүлийн тухай хуульд⁹ хүүхдийн эрх, ашиг сонирхлыг төрөөс хамгаалах, түүний ашиг сонирхлыг нэн тэргүүнд хамгаалах үүргийг баталгаажуулсан. Энэхүү зарчмын хэрэгжилтийн хүрээнд гэрлэлт цуцлах үед хүүхдийн асрамжийн асуудлыг эцэг, эх тохиролцоогүй тохиолдолд шүүх шийдвэрлэдэг. Ийнхүү хүүхдийн асрамжийг шүүхээр тогтоох зохицуулалт нь эцэг,

⁷ Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948), НҮБ, Парис, <https://legalinfo.mn/mn/detail/1271>

⁸ Монгол Улсын Үндсэн хууль (1992)-ийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх хэсэг.

⁹ Гэр бүлийн тухай хууль (1999)-ийн 4 дүгээр зүйлийн 4.4 ба 4.5.

эхийн хоорондын маргааныг шийдвэрлэхээс гадна хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах төрийн хамгаалалтын эрх зүйн механизм болж байна.

Монгол Улсын Гэр бүлийн тухай хууль (“ГБТХ”)-ийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт “Гэрлэгчид гэрлэлт цуцлах үед хүүхдээ хэний асрамжид үлдээх, түүнийг болон хөдөлмөрийн чадваргүй эхнэр, нөхрөө тэжээн тэтгэх, хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө хуваах тухайгаа бие даан, эсхүл эвлэрүүлэн зуучлалын журмаар харилцан тохиролцож болно.”, 14.6 дахь хэсэгт “Гэрлэгчид энэ хуулийн 14.5-д заасны дагуу тохиролцоогүй бол хүүхдийн нас, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэхийг нь харгалзан хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээх, тэтгэлгийн хэмжээг тогтоох, хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах асуудлыг шүүх шийдвэрлэнэ.” гэж тус тус зохицуулсан. Харин хамтын асрамж тогтоож болох талаар хуульд тодорхой заасан зохицуулалт байхгүй, мөн “хамтын асрамж” гэсэн ямар нэгэн нэр томъёо хуульд ашиглагдаагүй. Үүнээс дүгнэхэд, Монгол Улсад гэрлэлт цуцлах үед хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээхээр зохицуулсан буюу хүүхдийн ганцаарчилсан асрамжийг тогтоох хууль зүйн зохицуулалттай гэж ойлгож болохоор байна.

Гэхдээ ГБТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсэгт “Эцэг, эх гэрлэлтээ цуцлуулсан тохиолдолд энэ хуулийн 26.2-т заасан тэдгээрийн үүрэг хэвээр үлдэнэ.”, 26.5 дахь хэсэгт “Энэ хуулийн 26.4-т заасан тохиолдолд эцэг, эх үүргээ хэрэгжүүлэх журмыг тусгайлан тохиролцоогүй бол түүнийг шүүх тогтооно.”, 26.6 дахь хэсэгт “Хүүхдийн эрх, ашиг сонирхолд харшлахааргүй бол гэрлэлтээ цуцлуулсан эцэг, эхийн хэн нэг нь нөгөөдөө хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь саад учруулахыг хориглоно.” гэж тус тус заасан. Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т заасан эцэг, эхийн хүлээх үүрэгт дараах үүргүүд багтдаг:

- Хүүхдээ эрүүл чийрэг өсгөн бойжуулах, сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх;

- хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх;

- хүүхдээ үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх, түүнд суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадлага олгох;

- хүүхдийн эрхийг хамгаалж, үүргээ биелүүлэхэд нь туслах.

Үүнээс үзэхэд “Монгол Улсад гэрлэлт цуцлуулсан тохиолдолд хүүхдийн ганцаарчилсан асрамж тогтоодог” гэснээс өөр дүгнэлтэд хүргэж байна. Учир нь гэрлэлт цуцлагдсан ч гэсэн эцэг, эхийн

хүлээх үүрэг хэвээр үлдэх бөгөөд тухайн үүргүүдэд “хүүхдээ асран хамгаалах” үүрэг багтаж байна. Тэгвэл тухайн хүүхдийг асрамждаа авч байгаа эцэг эсхүл эхийн хувьд ямар эрх, үүрэгтэй гэсэн үг вэ буюу хүүхдийн асрамж, хүүхдийг асрамжид үлдээх гэдэг нь ямар агуулгатай вэ гэдэг асуулт урган гарч байна.

Хүүхдийн асрамжийн талаар хуульд тодорхой тайлбарласан тайлбар байхгүй байна. Харин Улсын дээд шүүх (“УДШ”)–ийн Гэр бүлийн холбогдолтой эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах зарим асуудлын тухай 2017 оны 03 дугаар зөвлөмжид¹⁰ хүүхдийн асрамжийн асуудлыг дараах байдлаар тайлбарласан байна.

- ГБТХ–ийн 26 дугаар зүйлийн 26.1.-д зааснаар эцэг, эх хүүхдээ хүмүүжүүлэхэд тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээдэг бөгөөд энэхүү эрх, үүрэг нь гэрлэлтээ цуцлуулсан хүмүүст ч мөн адил хамааралтай юм. Өөрөөр хэлбэл, гэрлэгчид нь гэрлэлтээ цуцлуулснаар эхнэр, нөхөр байхаа болих боловч эцэг, эх хэвээр үлддэг учир эцэг, эх байх эрхийг нь хуульд зааснаар хасаагүй тохиолдолд тэдгээрийн эрх, үүрэг хязгаарлагдахгүй болно.

- Шүүх гэрлэлтийг цуцалж, насанд хүрээгүй хүүхдийг эцэг, эхийнх нь хэн нэгний асрамжид үлдээж, нөгөө талаас тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэж буй нь эцэг, эхийн хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргийг хуваарилан хувааж буй асуудал биш юм. Гэрлэлтээ цуцлуулсан эцэг, эхийн хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүрэг хэн алинд нь хэвээр хадгалагддаг болно.

- Харин шүүх гэрлэлтийг цуцалж, хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээж буй явдал нь тусдаа амьдрах болсон эцэг, эхийн хэнтэй нь тухайн хүүхэд байнга оршин суухыг тодорхойлж, хүүхдийн амьдрах газрыг тогтоож байна гэсэн үг юм.

Олон улсад хүүхдийн асрамжийн ганцаарчилсан ба хамтын асрамж гэсэн 2 хэлбэр байх бөгөөд хамтын асрамж нь биечлэн асрамжлах (physical custody or residential custody) болон хууль зүйн асрамж (legal custody) гэсэн төрлүүдтэй. УДШ–ийн дээрх зөвлөмжид тусгаснаас үзэхэд хүүхдийн асрамжийг эцэг, эхийн хэн нэгэнд үлдээхээр шийдэж байгаа нь “... эцэг, эхийн хэнтэй нь тухайн хүүхэд байнга оршин суухыг тодорхойлж, хүүхдийн амьдрах газрыг тогтоож байна гэсэн үг юм” гэжээ. Үүнээс хуульд тодорхой тусгаагүй ч гэсэн Монгол Улсад хамтын асрамж хэрэгждэг гэж дүгнэж болохоор байна. Гэхдээ ямар хэлбэрээр вэ гэвэл “хууль зүйн асрамж” байж болох

¹⁰ Улсын Дээд шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 25–ны өдрийн 03 дугаар зөвлөмж, “Гэр бүлийн холбогдолтой эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах зарим асуудал”, <http://old.supremecourt.mn/act/view/244>

юм. Учир нь одоогийн хуулийн зохицуулалтуудаас дүгнэхэд хэрэв хүүхдийг эцгийн асрамжид үлдээхээр шүүх шийдвэл хүүхэд цаашид эцэгтэйгээ хамт амьдрах бөгөөд харин хүүхдийн асран хамгаалах, тэжээн тэтгэх эхийн үүрэг хэвээр байх буюу хүүхэдтэйгээ холбоотой асуудлуудад оролцох, шийдвэрлэх боломжтой байна гэж ойлгогдож байна.

Мөн түүнчлэн УДШ зөвлөмжид “... гэрлэгчид нь гэрлэлтээ цуцлуулснаар эхнэр, нөхөр байхаа болих боловч эцэг, эх хэвээр үлддэг учир эцэг, эх байх эрхийг нь хуульд зааснаар хасаагүй тохиолдолд тэдгээрийн эрх, үүрэг хязгаарлагдахгүй болно.” гэж тайлбарласнаас үзэхэд гэрлэлт цуцлалт нь ГБТХ-ийн 26.1-т заасан “Эцэг, эх хүүхдээ хүмүүжүүлэхэд тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ.” гэж тусгасан эцэг, эхийн эрх, үүргийг дуусгавар болгох үндэслэл болохгүй гэж үзэж болохоор байна. Гэхдээ хуульд хүүхдээ асрамжид авч үлдээгүй тал ямар эрхтэй байх талаар тодорхой тусгаагүйг дурдах нь зүйтэй.

Хуулийн дээрх зохицуулалтуудаас Монгол Улс нь гэрлэлт цуцлуулж байгаа тохиолдолд ганцаараа биечлэн асрах (sole physical custody) хэлбэр болон хамтын хууль зүйн асрамж (joint legal custody)-г хослуулан хэрэглэх боломжтой байна гэж дүгнэж болох ч, бодит нөхцөл байдал дээр энэ хэрхэн хэрэгжиж байгааг судалж үзэх шаардлагатай байна. Ийм дараагийн хэсэгт хүүхдийн асрамжтай холбоотой хуулийн хэрэгжилт ба шүүхийн практикийн талаар авч үзлээ.

V. Шүүхийн практик ба хэрэгжилтийн асуудал

Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайланд Гэрлэлт цуцлах хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийг түүвэрлэн судалжээ.¹¹ Судалгааны үр дүнд дараах дүгнэлт гарсан байна:

“Хэрэв асрамжийн талаар маргасан бол хүүхдийн санал, хүүхдийг хүмүүжүүлэхэд дутагдалтай тал илрэхгүй гэж үзвэл хүүхдийг эхийн асрамжид үлдээх хандлагатай, зарим тохиолдолд зөвхөн хүүхдийн саналыг авч асрамжийг шийдсэн байна. ... Түүнчлэн маргаагүй бол хүүхдийн саналыг авахгүй, эцэг, эхийн саналыг харгалзсан байдал ажиглагдаж байна. ... Мөн тусдаа амьдрах эцэг эсхүл эхийг хүүхэдтэйгээ уулзах уулзалтыг тогтоож шийдвэрлэсэн тохиолдол байхгүй байгааг анхаарах шаардлагатай болжээ.”

¹¹ Хууль зүй, дотоод хэргийн яам, “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан”, 2024, https://legalinfo.mn/storage/uploads/process/202509/file_1758095566017658_17150637498810689.pdf

Мөн гэрлэлт цуцлалтын хэргийг шийдвэрлэсэн Монгол Улсын шүүхийн шийдвэрүүдэд нэхэмжлэгч талын нэхэмжлэлийн шаардлага, хариуцагч талын сөрөг нэхэмжлэл, талуудын хүсэлт, шаардлагыг үндэслэн гэрлэлт цуцлах шаардлагатай хамт хүүхдийн асрамж, тэтгэлгийн асуудлыг шийдвэрлэдэг. Гэвч талуудаас хүүхдийн асрамж, тэтгэлэгтэй холбоотой аливаа нэхэмжлэл, хүсэлт гаргаагүй бол шийдвэрлэхгүй үлдээх тохиолдлууд байна гэж дээрх тайланд мөн дурдсан байна.¹² Ийнхүү шийдвэрлэх үндэслэл нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1 дэх хэсэг, 132 дугаар зүйлийн 132.5 дахь хэсгүүдэд заасан зохицуулалтаас үүдэлтэй гэж үзэж байна.

Шүүх гэрлэлт цуцлалтыг шийдвэрлэхдээ хүүхдээ асрамждаа авч үлдээгүй эцэг эсхүл эхийг хуулиар хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхэд хүүхдийг асрамжилж буй тал ямар нэгэн байдлаар саад учруулахгүй байх талаар дурддаг боловч энэхүү шүүхийн шийдвэрийн биелэлтийг хэрхэн хангах нь ойлгомжгүй байна. Монгол Улсын хуульд гэрлэлт цуцалсны дараа эцэг, эх хүүхэдтэйгээ холбоотой байх, уулзах эрхийн талаар зохицуулалт байхгүй. Мөн хоорондын зөрчил ихтэй эцэг, эхүүдийн хувьд хүүхдээ асрамждаа байлгадаггүй нөгөө талтай хүүхдээ уулзуулах нь ихэнх тохиолдолд боломжгүй зүйл бөгөөд шүүхийн шийдвэрт хүүхэдтэйгээ уулзах эрхийн талаар тодорхой заагаагүйн улмаас тухайн талын эрх нь зөрчигдөхөд хүрдэг. Мөн хүүхдийн асрамжийн талаар эцэг, эхийн эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхой зааглаж ялгаагүй, тодорхойгүй байдлын улмаас хүүхэдтэйгээ уулзуулах, хүүхдийнхээ талаар шийдвэр гаргах асуудал нь эцсийн эцэст хүүхдийг асрамждаа авсан талын бүрэн эрхийн асуудал болдог байна.

Иймд бодит байдал дээр хүүхдийн асрамжийн асуудал хэрхэн хэрэгжиж байгаагаас дүгнэвэл эцэг, эх хоорондоо тохиролцож хүүхдийн асрамжийн асуудал дээр эвтэй найртай байдгаас бусад тохиолдолд хүүхдийг асрамждаа авч үлдсэн тал хүүхдээ биечлэн асрах, түүний талаар шийдвэр гаргах эрх, үүргээ дангаар хэрэгжүүлдэг. Энэ нь хүүхдийн ганцаарчилсан асрамжийн хэлбэр ихэнх тохиолдолд үйлчилж байгааг харуулж байна.

Монгол Улс дахь хүүхдийн асрамж тогтоохтой холбоотой эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтийн байдлаар дүгнэхэд дараах тулгамдсан асуудлууд байна гэж үзэж байна:

- Хууль зүйн тодорхой бус байдал – Хуульд хүүхдийн асрамжийн асуудлыг тодорхой зохицуулаагүйн улмаас эргэлзээтэй нөхцөл байдлыг үүсгэсэн. Шүүх хүүхдийн асрамжийг шийдвэрлэхэд энэхүү

¹² Мөн тэнд.

нөхцөл байдал нь хүндрэл үүсгэдэг.

- Эцэг, эхийн эрхийн тэнцвэргүй байдал, хүүхэдтэйгээ уулзах эрхийн зохицуулалтын дутагдал - Хүүхдээ асрамждаа авч үлдээгүй эцэг эсхүл эхийн эрх болон хүүхдийн эрх зөрчигдөх, тухайн эцэг эсхүл эх хүүхэдтэйгээ холбоотой байх, уулзах боломжгүй болох гэх мэт.

- Хүүхдийн тэжээн тэтгэх үүргийн хэрэгжилт – Хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний асрамжид үлдээснээр нөгөө тал нь тодорхой хэмжээний тэтгэлгийг нөгөө талд төлөх үүрэг хүлээдэг. Энэхүү үүргээ хүүхдээ тэжээн, тэтгэх үүргээ бүрэн биелүүлж байгаа гэж үздэг. Улмаар шүүхийн шийдвэрийн дагуу төлөх тэтгэлгээс илүү гарсан аливаа зардал, төлбөрийг төлөх хүсэлгүй, мөн үүрэггүй гэж үзэх нийтлэг байдал ажиглагддаг. Мөн шүүхийн шийдвэрийн дагуу тэтгэлэг төлөх үүргийн хэрэгжилт маш хангалтгүй байгаа нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын статистик мэдээллээс харагдсан байна.¹³

- Гэр бүлийн бүтэц өөрчлөгдөж буй нийгмийн нөхцөлтэй хууль, эрх зүйн орчныг нийцүүлэх хэрэгцээ шаардлага тулгарсан.

- Гэр бүлийн хөрөнгийн эрх, гэр бүлийн дундын хөрөнгө хуваахтай холбоотой асуудал – Хүүхэд нь гэр бүлийн гишүүн тул гэр бүлийн дундын хөрөнгөөс өмчлөх эрхтэй гэж үзэн шүүх гэр бүлийн дундын хөрөнгө хувааж шийдвэрлэхдээ хүүхдээ ногдох хувийг хүүхдээ асрамждаа авч буй эцэг, эсхүл эхэд ногдох хувьд нэгтгэж тооцон, зөрүүг гаргуулахаар шийдвэрлэдэг практик тогтсон. Үүнтэй холбоотойгоор хүүхдийн ашиг сонирхол гэхээс илүүтэй эд хөрөнгийн асуудлыг чухалчилж үзэн хүүхдээ асрамждаа үлдээхээр талууд маргах нь түгээмэл болсон гэж Гэр бүлийн хуулийн шинэчлэлтэй холбоотой хэлэлцүүлэгт дурдагдсан байна.¹⁴

2025 онд Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Уг төслийн 13 дугаар зүйлийн 13.8-д шүүх хүүхдийн асрамжийг шийдвэрлэхдээ хүүхдийн нас, эцэг, эхийн халамж, ахуйн нөхцөл, чадавх, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэх, мөн хүүхдийн хүсэл, сонирхол, суралцах, хөгжихөд таатай орчныг харгалзан үзэхээр заасан. Түүнчлэн талууд хүүхдийн асрамжийн талаар харилцан тохиролцсон тохиолдолд уг

¹³ Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, 2025, <https://d.parliament.mn/tusul/1591e85c-f4ef-4fcf-90e7-a0f708b9bb18>.

¹⁴ Жигжидийн Лхагвасүрэн, “Монгол Улс дахь хүүхдийн асрамжийн эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал”, *Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр бүл*” олон улсын эрдэм шинжилгээний хурал (1 хэсэг) (2025.06.25), Улаанбаатар хот, Монгол улс, <https://legaldata.mn/news/444>

тохиролцоог шүүх харгалзан үзэхээр тусгажээ. Харин 13.9-д хүүхдийн асрамжийг дангаар болон хамтран хэрэгжүүлэх хэлбэртэй байж болохыг, 34 дүгээр зүйлд “Эцэг, эхийн эрх, үүргээ хэрэгжүүлэх гэрээ” зэрэг одоогийн хуульд байгаагүй шинэ зохицуулалтуудыг тусгасан байна.

Хэдийгээр дээрх зохицуулалтууд нь хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд дэвшилттэй алхам болсон ч “хамтран хэрэгжүүлэх” гэх ойлголтын агуулга тодорхой бус хэвээр байна. Төслийн 31 дүгээр зүйлийн 31.1-д эцэг, эх нь гэрлэсэн эсэх, хамт амьдарч байгаа эсэхээс үл хамааран хүүхдийн өмнө тэгш эрх эдэлж, хамтын үүрэг, хариуцлага хүлээхээр заасан. Үүнээс үзэхэд шүүх хүүхдийн асрамжийг дангаар эсхүл хамтран хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэнээс үл шалтгаалан хууль зүйн хамтын асрамжийн зарчим үйлчлэхээр байна. Иймд хуулийн төсөлд дурдсан “хамтран хэрэгжүүлэх” гэдэг нь хүүхдийг биечлэн асрах хэлбэрийг илэрхийлж байгаа гэж ойлгогдож байна. Гэхдээ хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, зохицуулалт хоорондын зөрчилдөөнгүй байдлыг хангах үүднээс хүүхдийн асрамжийг хамтран хэрэгжүүлэх тухай ойлголт, зохицуулалтыг хуульд илүү тодорхой, нарийвлан тусгах шаардлагатай байна гэж дүгнэлээ.

VI. Олон улсын туршлага ба судалгааны үр дүн

A. Хамтын асрамжийн хэлбэр дэлхий даяар түгээмэл ашиглагдаж байна уу?

20-р зууны сүүл, 21-р зууны эхээр жендэрийн эрх тэгш байдлыг хангахтай холбоотой хөдөлгүүнүүд, нийгмийн хэвшмэл ойлголтуудыг халсан ололт амжилтуудын үр дүнгүүдийн нэг нь хүүхдийн хамтын асрамжийг дэлхийн улс орнуудад зөвшөөрдөг болсон явдал юм. Өнөө үед хүүхдийн хамтын асрамжийг улс орнууд хүлээн зөвшөөрөх нь нэмэгдсээр байгаа¹⁵ бөгөөд хүүхдийн хамтын асрамж гэдэг ерөнхий агуулгын хүрээнд улс орнууд өөр өөрийн онцлогт нийцүүлсэн зохицуулалтуудыг хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлж байна.

Америк болон Европын улсуудад хүүхдийн хамтын асрамжийг хэрэгжүүлж буй тоон мэдээг судалж үзвэл:

1. Европ: 50 орчим Европын улсын 90% орчим нь ямар нэг хэмжээнд хамтын асрамжийн хэлбэрийг хүлээн зөвшөөрдөг.¹⁶

¹⁵ Anne Brons, M. D., M.Kalmijn, and A.-R.Poortman, “The Socioeconomic Gradient in Joint Physical Custody: A Comparison of 32 Countries.”, *Journal of Marriage and Family* (February 2026), 1–15. <https://doi.org/10.1111/jomf.70056>

¹⁶ Milla Salin, Daniel R. Meyer, Mia Hakovirta, Eija Lindroos, “Factors Associated with the Joint Physical Custody of European Children”, *Population Research and Policy Review*, *Springer; Southern Demographic Association (SDA)*, vol. 43(4) (August 2024),

2. Америк: Тус тив дэх 35 улсын ихэнх нь ямар нэг хэмжээнд хамтын асрамжийн хэлбэрийг хүлээн зөвшөөрдөг.

3. Ази: Тодорхой тоон мэдээлэл байхгүй ч Хятад (2025 оноос), Япон (2026 оноос), Өмнөд Солонгос, Тайланд болон Энэтхэг, Пакистан, Непал, Бангладеш зэрэг Өмнөд Азийн улсууд хамтын асрамжийг зөвшөөрдөг.

4. Африк: Тодорхой тоон мэдээлэл байхгүй байна. Гэхдээ Африкийн хэд хэдэн орны гэр бүлийн хууль тогтоомж нь хамтран асран хамгаалах зохицуулалтыг хүлээн зөвшөөрдөг. Жишээлбэл Өмнөд Африкийн Хүүхдийн тухай хуульд эцэг, эхчүүд эрх, үүрэг хариуцлагаа (асран халамжлах, холбоо барих) хуваалцах боломжийг олгодог бөгөөд Кени, Этиопт хүүхдийн асрамж тогтоох шийдвэрт эцэг, эх эрх, үүргээ хамтран хэрэгжүүлэх талаар тусгаж болдог.

5. Номхон далайн орнууд: Тухайн бүс нутгийн томоохон төлөөллүүд болох Австрали ба Шинэ Зеландад хамтын асрамжийг зөвшөөрдөг.

Америк болон Европын нийт 37 улсын мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийсэн судалгаанд хойд болон төв Европын улсууд, Канадад хүүхдийн хамтын асрамжийг илүү түгээмэл ашигладаг ба хууль хэрэгжиж эхэлснээс хойш жил ирэх тутам хамтын асрамж тогтоох хувь өссөөр байгаа гэж дурдсан байна.¹⁷ Харин өмнөд болон зүүн Европын улсуудад харьцангуй бага тоон үзүүлэлт гарсан байна. Хүүхдийн хамтын асрамжийн талаар улс орнуудын хооронд тоон мэдээлэл үзүүлэлтүүд ч ялгаатай байна. Жишээлбэл, Швед улс 21% орчим хүүхдийн хамтын асрамжийг хэрэгжүүлдэг бол Бельги 14%, Исланд 12%, Дани 10%-ийн үзүүлэлттэй байна.¹⁸ Харин бусад улс орнуудад энэ хувь 5%-аас бага байдаг.

Ийнхүү дэлхийн улс орнуудад хамтын асрамжийг илүү өргөн хүрээнд хэрэгжүүлж, үр дүнд нь хүүхдийн хамтын асрамжийн хувь хэмжээ жил ирэх тусам өсөж байгаа нь улс орнуудад энэхүү хууль эрх зүйн зохицуулалтын ач холбогдлыг илтгэж байна.

Б. Coparenting/joint custody-н хүүхдэд үзүүлэх нөлөө

Өмнөх хэсэгт дурдсанчлан, эцэг, эх гэрлэлтээ цуцлуулах эсхүл хамтын амьдралаа дуусгавар болгох үед хүүхдийн асрамжийг хэрхэн зохицуулах нь хүүхдийн сайн сайхан байдал (wellbeing)¹⁹д шууд нөлөө

1-25.

¹⁷ Steinbach A, Augustijn L, Corkadi G., “Joint Physical Custody and Adolescents’ Life Satisfaction in 37 North American and European Countries”, *Family Process*, 60(1) (March 2021), 145-158, retrieved from <https://pubmed.ncbi.nlm.nih.gov/32293039/>

¹⁸ Сүүлийн үеийн нээлттэй мэдээллээс харахад эдгээр хувь хэмжээ бараг 2 дахин нэмэгдсэн байна.

¹⁹ Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль (2024)-ийн 4 дүгээр зүйлийн 4.1

үзүүлэх чухал асуудал болдог. Ийм нөхцөлд хүүхдийн асрамжийг ямар хэлбэрээр тогтоох нь хүүхдийн сэтгэл зүй, нийгмийн хөгжил, амьдралын нөхцөлд илүү эерэг нөлөө үзүүлэх вэ гэдэг асуудалд олон улсын судлаачид анхаарал хандуулж ирсэн.

Хүүхдийн хамтын асрамжийг хууль тогтоомжид тусгах гол зорилго нь гэрлэлт цуцлалтын дараа хүүхэд эцэг, эхийн аль алинтай нь харилцаагаа хадгалах боломжийг бүрдүүлэх, эцэг, эхэд хүүхдээ асран хамгаалах үүрэг, хариуцлагыг хуваарилан хэрэгжүүлэх нөхцөлийг бий болгох, хүүхдийн сайн сайхан байдлыг хамгаалах явдал юм. Түүнчлэн хүүхдийн асрамжийг нэг талд төвлөрүүлэхгүйгээр эцэг, эх хоёуланд нь тодорхой үүрэг, оролцоог хадгалах нь хүүхдийн амьдралд тогтвортой орчныг бий болгоход ач холбогдолтой гэж үздэг. Гэвч гэрлэлт цуцлалтын дараа хамтын асрамж тогтоох нь бодит байдал дээр хүүхдийн сайн сайхан байдалд үнэхээр эерэг үр нөлөө үзүүлдэг эсэх талаар судалгааны түвшинд нэлээд хэлэлцүүлэг өрнөсөн байна.

Сүүлийн зуун жилийн хугацаанд өрнөдийн нийгэмд гэр бүлийн бүтэц эрс өөрчлөгдөж, хүүхэд төрсөн эцэг, эхийн хамт өсөх хувь мэдэгдэхүйц буурсан байна. Судалгаанд 1920 онд хүүхдүүдийн 90 гаруй хувь нь 18 нас хүртлээ өөрийн төрсөн эцэг, эхийн хамт өсөж, хүмүүждэг байсан бол 2020 он гэхэд энэ үзүүлэлт эрс буурч, нийт хүүхдүүдийн гуравны нэгээс бага хувь буюу ойролцоогоор 29 хувь нь элэг бүтэн гэр бүлд өсөж байна гэж тэмдэглэсэн байдаг.²⁰ Мөн нийт хүүхдүүдийн 60% нь л гэрлэсэн эцэг, эхийн дундаас төрж байгаа (Ventura 2009; Martin et al. 2019) бөгөөд тэдний тал хувь нь 18 нас хүрэхээсээ өмнө эцэг, эхийнхээ хэн нэгний эсхүл хоёулангийнх нь асрамжаас гарч байгаа нь ажиглагдсан байна.²¹

Энэхүү өөрчлөлт нь нийгэм, эдийн засаг, соёлын олон хүчин зүйлтэй холбоотой гэж үздэг. Тухайлбал, хөдөө аж ахуйн эдийн засгаас хот төвлөрсөн, аж үйлдвэржсэн нийгэм рүү шилжсэн явц нь гэр бүлийн бүтцийг өөрчилж, гишүүдийн тоо цөөрсөн жижиг гэр бүлийг бий болгох хандлагыг нэмэгдүүлсэн байна. Мөн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэх, жирэмслэлтээс хамгаалах арга хэрэгсэл хөгжих, гэрлэлт болон хамтын амьдралын талаарх нийгмийн ойлголт өөрчлөгдөх зэрэг хүчин зүйлс гэр бүлийн харилцаанд мэдэгдэхүйц

дэх хэсгийн 4.1.1-т “Хүүхдийн сайн сайхан байдал гэж хүүхдийн бие махбод, эрүүл мэнд, сэтгэл санаа, нийгэмшихүй, танин мэдэхүй, боловсрол, эдийн засгийн хэрэгцээ, шаардлага хангагдсан, хүүхдийн хөгжлийг дэмжсэн орчин нөхцөлийг” гэж тодорхойлсон.

²⁰ Pew Research Center, Parenting in America: Outlook, worries, aspirations are strongly linked to financial situation, (2015), www.pewresearch.org (last accessed: 2026.03.13)

²¹ Amato, P. R., “The Consequences of Divorce for Adults and Children”, *Journal of Marriage and Family*, Vol. 62, No. 4 (November 2000). 1269–1287. <https://www.jstor.org/stable/1566735>

нөлөө үзүүлсэн. Үүний үр дүнд гэрлэлт цуцлалтын тоо нэмэгдэж, ганц бие эцэг, эхтэй гэр бүлийн тоо эрс өссөн байна.²²

Саллины хийсэн энэхүү судалгаагаар уламжлалт гэр бүл (nuclear family)²³-ийн хэлбэр болон бусад гэр бүлийн хэлбэр (ганц бие эх эсхүл эцэг, дахин гэрлэлт гэх мэт)-ийн хувьд хүүхдийн сайн сайханд үзүүлэх нөлөөлөл нь ялгаатай юу, уламжлалт гэр бүлд өссөн хүүхэд бусад хэлбэрийн гэр бүлд өссөн хүүхдээсээ илүү сайн сайхан амьдрах нөхцөл нь хангагдаж байна уу гэдгийг хүн амын статистик тоо мэдээ, өмнөх судалгаануудын үр дүнд үндэслэн дүгнэсэн байна. Үр дүнд нь уламжлалт гэр бүлд өсөөгүй хүүхдийн хөгжил нь уламжлалт гэр бүлд өссөн хүүхдийнхээс доогуур байгаа нь ажиглагдсан гэжээ.

Гэрлэлт цуцлалт нь хүүхдийн амьдралд олон талын нөлөө үзүүлдэг болохыг судалгаанууд харуулдаг. Пол Аматогийн 2014-д гэрлэлт цуцлалтын 10 жилийн мэдээлэлд үндэслэн хийсэн судалгаагаар эцэг, эхийн хамт амьдарч байгаа хүүхдүүдтэй харьцуулахад гэрлэлт цуцлагдсан гэр бүлд өссөн хүүхдүүд зан төлөвийн асуудалтай болох, сэтгэл зүйн тогтворгүй байдалд өртөх, сурлагын амжилт буурах зэрэг эрсдэлд илүү өртөх хандлагатай байдаг гэж дүгнэсэн. Судалгаанд мөн гэрлэлт цуцлалтын дараа хүүхдүүд эцэг, эхийнхээ хэн нэгнээс, ихэвчлэн эцгээсээ холдож, харилцаа нь сулардаг нь хүүхдийн сайн сайхан байдалд сөргөөр нөлөөлж болохыг дурдсан байна.²⁴

Гэрлэлт цуцлалтын дараа хүүхдийн сайн сайхан байдлыг алдагдуулж байгаа гол шалтгаан нь хүүхдийн амьдралд эцгийн оролцоо нь маш их багассан эсхүл бүр мөсөн байхгүй болсонтой холбоотой гэж үзсэн байна. Учир нь АНУ-д хүүхдийн асрамжийн талаар гарсан шийдвэрүүдийн 85% нь хүүхдийг эхийн асрамжид үлдээхээр шийддэг бөгөөд улмаар эцгийн үүрэг оролцоо хүүхдийн хувьд маш их багасдаг. Хүүхдийг эхийн асрамжид ихэвчлэн үлдээхээр шийдвэрлэдэг гол шалтгаан нь эхийн асрамж нь хүүхдүүдийн хүмүүжилд эцгийнхээс илүү чухал ач холбогдолтой бөгөөд хүүхэд бага насандаа эхтэйгээ илүү дотно харилцаатай байдаг гэж үздэгтэй холбоотой.²⁵

²² Sullins, D. P., “The Case for Mom and Dad”, *the Linacre Quarterly*, 88(2) (March 2021), 184-201. https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=3744451

²³ Уламжлалт гэр бүл буюу nuclear family гэдэг нь эцэг, эх нь хүүхдүүдийнхээ хамт амьдарч буй гэр бүлийн хэлбэр юм.

²⁴ Amato, P. R., “The Consequences of Divorce for Adults and Children: An Update”, *Drustvena Istrazivanja; Zagreb* Vol. 23, No.1, (2014), 5–24, retrieved from <https://hrcak.srce.hr/file/180281>

²⁵ Үүнийг 19-р зуунд түгээмэл ашиглагдаж байсан “Tender years doctrine”-той холбож тайлбарладаг бөгөөд энэ зарчмын дагуу бага насны хүүхэд (7 нас хүртэлх)-г эх нь асарч хамгаалах нь илүү зохимжтой гэж үздэг. Одоо энэ зарчмыг баримтлахаа больж хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангах зарчмыг баримталдаг болсон ч Монгол Улсын шүүхийн шийдвэрүүдээс харахад энэ зарчмын нөлөө байсаар

Ийм нөхцөлд эцгийн оролцоог хадгалах нэг боломжит механизм нь хамтын асрамжийн зохицуулалт гэж зарим судлаачид үздэг. Тухайлбал, Роберт Базермэн-ий хийсэн мета-анализ судалгаагаар хамтын асрамжид байгаа хүүхдүүдийн сэтгэл зүйн дасан зохицох чадвар (adjustment) болон нийгмийн харилцааны үзүүлэлт нь ганцаарчилсан асрамжид байгаа хүүхдүүдтэй харьцуулахад харьцангуй илүү сайн байсан гэж дүгнэсэн байна. Судлаачдын тайлбарласнаар хамтын асрамжийн үед хүүхэд эцэг, эхийн аль алинтай нь ойр дотно харилцаагаа хадгалах боломжтой бөгөөд энэ нь хүүхдийн сэтгэл зүйн тогтвортой байдалд эерэг нөлөө үзүүлэх боломжтой байдаг гэжээ.²⁶

Мөн Скандинавын орнуудад хийсэн зарим судалгааны үр дүн үүнийг тодорхой хэмжээгээр баталгаажуулдаг. Тухайлбал, 2016 онд хэвлэгдсэн судалгаанд уламжлалт гэр бүлд амьдарч байгаа 3639 хүүхэд, ганцаарчилсан асрамжид байгаа 654 хүүхэд, хамтын асрамжид байгаа 391 хүүхдийн мэдээллийг харьцуулан шинжилсэн бөгөөд хамтын асрамжид байгаа хүүхдүүдийн сэтгэл зүйн үзүүлэлт нь уламжлалт гэр бүлд амьдарч буй хүүхдүүдийнхтэй ойролцоо байсан бол ганцаарчилсан асрамжид байгаа хүүхдүүдийн хувьд харьцангуй сул үзүүлэлт ажиглагдсан байна.²⁷

1980-1991 он хүртэлх АНУ-ын мужуудын статистик мэдээлэлд үндэслэн хамтын асрамжийн хууль эрх зүйн хэрэгжилтийн гэрлэлт цуцлалтын тоо болон хүүхдээ тэжээн тэтгэх үүргийн биелэлтэд үзүүлж буй нөлөөллийг судалсан судалгаа 1998 онд хэвлэгдсэн байна. Судалгааны үр дүнд хамтын асрамжийн хуулийг хэрэгжүүлснээр гэрлэлт цуцлалтын тоо буурсан гэж дүгнэжээ. Энэ үр дүнг Бондинг онолтой холбон тайлбарласан бөгөөд уг онол нь, хэрэв эцэг, эх, ялангуяа эцэг нь гэр бүлээ цуцалсан ч хүүхдийнхээ хувьд харилцаагаа таслахгүй гэдэг ойлголттой байх нь түүний хүүхэдтэйгээ дотно харилцааг хадгалахад тусалдаг гэж үздэг. Үүний улмаас гэрлэлт цуцлалтын тоог бууруулахад нөлөөлдөг гэж үзжээ. Мөн судалгаагаар хамтын асрамж нь хүүхдийн тэжээн тэтгэх үүргийн биелэлтийг сайжруулдаг гэсэн дүгнэлт гарсан бөгөөд энэ үзэгдлийг Мониторинг онолтой холбон тайлбарласан. Мониторинг онол нь, хамтын асрамжид байгаа хүүхдүүдэд тэжээн тэтгэгч талын олгосон тэтгэмжийн зохистой

байна.

²⁶ Bauserman, R., “Child Adjustment in Joint-Custody Versus Sole-Custody Arrangements: Meta-Analytic Review”, *Family Psychology*, Vol. 16, No. 1 (2002), 91-102, <https://www.apa.org/pubs/journals/releases/fam-16191.pdf>

²⁷ Fransson E, Turunen J, Hjern A, Östberg V, Bergström M., “Psychological complaints among children in joint physical custody and other family types: Considering parental factors”, *Scandinavian Journal of Public Health*, 44(2) (March 2016), 177-183, https://nebraskajudicial.gov/sites/default/files/odr/psychological_complaints.pdf

зарцуулалтыг хянах боломж нь тэдний үүргийн биелэлтийг илүү сайн хангах боломжийг бүрдүүлдэг гэж үздэг.²⁸

Гэрлэлт цуцлалтын дараах хүүхдийн хамтын асрамж хамгийн түгээмэл хэрэгждэг Швед улсад хийсэн судалгаагаар гэрлэлт цуцлагдсаны дараа эцэг, эхтэйгээ аль алинтай нь хамт амьдрах боломжтой буюу хамтын асрамжид байдаг хүүхдүүдийн хувьд стресст өртөх нь харьцангуй бага байна гэж дүгнэжээ. Энэхүү үр дүн нь хэдий эцэг, эх нь хамт амьдрахаа больсон ч гэсэн эцэг, эхийн аль алинтай нь өдөр тутамдаа холбоотой байж, хамт амьдрах нь хүүхдэд эерэг нөлөө үзүүлж байгаатай холбоотой гэж тайлбарласан байна.²⁹

Нөгөө талаар хамтын асрамж нь хүүхдийн амьдралын тогтвортой байдал, хүүхдийн сурлага, улмаар ирээдүйн хөдөлмөрийн зах зээлд үзүүлэх нөлөөлөл нь сөрөг гэж дүгнэсэн судалгаанууд ч мөн байна. Ялангуяа эцэг, эх хоорондын зөрчил өндөр хэвээр байгаа нөхцөлд хүүхэд хоёр талын маргаанд татагдан орж, сэтгэл зүйн дарамтад өртөх эрсдэлтэй байдаг гэж үзсэн байна.

Дээрх судалгаануудын үр дүнгээс үзэхэд гэрлэлт цуцлалтын дараах хүүхдийн асрамжийн хэлбэр нь хүүхдийн сэтгэл зүй, нийгмийн хөгжил, амьдралын нөхцөлд тодорхой нөлөө үзүүлдэг болох нь харагдаж байна. Судалгааны зарим үр дүнгээс хамтын асрамжид байгаа хүүхдүүдийн хувьд эцэг, эхийн аль алинтай нь харилцаагаа хадгалах боломж бүрддэг тул сэтгэл зүйн дасан зохицолт болон сайн сайхан байдлын үзүүлэлт харьцангуй өндөр байж болохыг тэмдэглэсэн байна. Гэсэн хэдий ч хамтын асрамж нь бүх нөхцөлд ижил үр дүн авчирна гэж үзэх боломжгүй бөгөөд эцэг, эх хоорондын харилцаа, хүүхдийн нас, амьдралын нөхцөл зэрэг олон хүчин зүйлээс ихээхэн хамааралтай байдаг. Иймээс хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьж, тухайн гэр бүлийн нөхцөл байдалд нийцсэн шийдвэр гаргах шаардлагатай гэж үзэж байна.

VII. Дүгнэлт, санал

Энэхүү судалгаагаар гэрлэлт цуцлагдсаны дараах хүүхдийн асрамжийн эрх зүйн зохицуулалтыг олон улсын туршлага болон Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд харьцуулан шинжиллээ. Судалгааны үр дүнд Монгол Улсад хүүхдийг эцэг, эхийн хэн нэгний

²⁸ Brinig, Margaret, and F. Buckley, "Joint Custody: Bonding and Monitoring Theories", *Indiana Law Journal*, Vol. 73, No.2 (Spring 1998), <https://www.repository.law.indiana.edu/ilj/vol73/iss2/>

²⁹ Turunen, J., "Shared Physical Custody and Children's Experience of Stress", *Journal of Divorce Remarriage*, Vol. 58, No.5 (2017), 371-392. <https://www.tandfonline.com/doi/figure/10.1080/10502556.2017.1325648?scroll=top&needAccess=true>

асрамжид үлдээх ганцаарчилсан хэлбэр зонхилж байгаа нь хүүхдийн дээд ашиг сонирхлыг хангахад тодорхой хүндрэл учруулж болохыг дүгнэв. Олон улсын туршлагаас харахад хамтын асрамж нь эцэг, эхийн эрх, үүргийн тэнцвэрийг хадгалах, хүүхдийн эцэг, эхтэйгээ харилцах эрхийг хамгаалах, хүүхдийн хөгжлийг дэмжихэд илүү үр дүнтэй болохыг харуулж байна. Мөн улс орнуудад гэр бүлийн хүчирхийлэл, эцэг, эхийн болон хүүхдийн онцгой нөхцөл байдал зэрэг хамтын асрамж тогтоох боломжгүйгээс бусад тохиолдолд хамтын асрамжийг тогтоохыг эрмэлзэх нь хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцтэй гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, хамтын асрамжийн ойлголт болон гэрлэлт цуцлалтын дараа ч хүүхэд ба эцэг, эх хоорондын харилцааг хадгалж үлдэх нөхцөлийг бүрдүүлэх, дэмжих зохицуулалтуудыг хууль тогтоомжид тусгах шаардлагатай гэж үзэв. Энэ нь хүүхдийн эрхийг илүү бүрэн хамгаалах, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэхэд эцэг, эхийн оролцоог тэнцвэртэй хангах, нийгмийн тогтвортой байдлыг дэмжих ач холбогдолтой. Цаашид хамтын асрамжийн хэрэгжилтийн практик, хүүхдийн санал бодлын нөлөө, эцэг эхийн харилцааны онцлогийг нарийвчлан судлах нь чухал байна.

[Ном зүй]

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, 2025 он.

Гэр бүлийн тухай хууль, 1999 он.

Жигжидийн Лхагвасүрэн, “Монгол Улс дахь хүүхдийн асрамжийн эрх зүйн зохицуулалтын тулгамдсан асуудал.”, Дагнасан шүүхийн тогтолцоо: Хүүхдийн эрх ашиг ба гэр бүл” олон улсын эрдэм шинжилгээний хурал (I хэсэг), 2025 он.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, 2002 он.

Монгол Улсын Үндсэн хууль, 1992 он.

Улсын Дээд шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 03 дугаар зөвлөмж, Гэр бүлийн холбогдолтой эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд анхаарах зарим асуудал.

Хүүхэд хамгааллын тухай хууль, 2024 он.

Хууль зүй, дотоод хэргийн яам, “Гэр бүлийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны тайлан”, 2024 он.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1948 он.

Хүүхдийн эрхийн тухай конвенц, 1989 он.

Amato, P. R., “The Consequences of Divorce for Adults and Children”, *Journal of Marriage and Family* 62, no. 4 (2000).

Amato, Paul R., Jennifer B. Kane, and Spencer James, “Reconsidering the ‘Good Divorce.’”, *Family Relations* 60, no. 5 (2011).

Amato, P. R., “The Consequences of Divorce for Adults and Children: An Update”, *Drustvena Istrazivanja; Zagreb* 23, no. 1 (2014).

Anja Steinbach, L. A., “Joint Physical Custody and Adolescents' Life Satisfaction in 37 North American and European Countries”, *Family Process* 60, no. 1 (2021).

Anne Brons, M. K. R., “The Socioeconomic Gradient in Joint Physical Custody: A Comparison of 32 Countries”, *Journal of Marriage and Family*, (2026).

Bauserman, R., “Child Adjustment in Joint-Custody Versus Sole-Custody Arrangements: Meta-Analytic Review”, *Family Psychology* 16, no. 1 (2002)

Brinig, Margaret, and F. Buckley, “Joint Custody: Bonding and Monitoring Theories”, *Indiana Law Journal* 73, no. 2 (1998).

Emma Fransson, J. T., “Psychological complaints among children in joint physical custody and other family types: Considering parental factors”, *Scandinavian Journal of Public Health* 44, no. 2 (2016).

Government of Canada, Department of Justice, “Section 3: Parenting after Separation—Focusing on Your Children - Making Plans: A Guide to Parenting Arrangements after Separation or Divorce.” (2013), <https://www.justice.gc.ca/eng/fl-df/parent/mp-fdp/p4.html>

Pruett MK, Hoganbruen K., “Joint Custody and Shared Parenting. Research and interventions.”, *Child Adolesc Psychiatr Clin N Am* (1998).

Justia, Joint vs. Sole Custody, (2018), <https://www.justia.com/family/child-custody-and-support/child-custody/joint-vs-sole-custody/>

Milla Salin, Daniel R. Meyer, Mia Hakovirta, Eija Lindroos, “Population Research and Policy Review”, (2024).

Parker, K. J., “Parenting in America”, Pew Research Center, (2015), www.pewresearch.org

Sullins, D. P., “The Case for Mom and Dad”, *the Linacre Quarterly* 88, no. 2 (2021).

Turunen, J., “Shared Physical Custody and Children’s Experience of Stress”, *Journal of Divorce Remarriage* 58, no.5 (2017).

[Abstract]

Joint Child Custody: International Practices and Challenges in Mongolia

Baljinsuren Munkhtur

Bachelor of Laws (LL.B.).

Ulaanbaatar, Mongolia

This article examines the legal regulation of child custody following divorce in Mongolia, compared with international practices and principles. The study explores the theoretical foundations of sole and joint custody, the principle of the best interests of the child, and global trends in family law. In Mongolia, custody is predominantly granted to one parent, often the mother, which may limit the balance of parental rights and responsibilities and restrict the child's right to maintain relationships with both parents. International experience suggests that joint custody can better safeguard children's rights, highlighting the need to refine Mongolia's legal framework. The study identifies the advantages and disadvantages of joint custody and proposes recommendations for introducing joint custody arrangements into Mongolian law.

[Keywords]

Child Custody, Sole Custody, Joint Custody, Family Law, The Best Interests of the Child, Co-parenting.